

28

10

**БАТЛАВ.**

ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ АЖ АХУЙН ЯАМНЫ  
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА **Х.ЗОЛЖАРГАЛ**



**ЗЭЭЛИЙН ГЭРЭЭ**

Баталгаатар хот

2014.03.17

Гэрээний дугаар: ММУХ/ТШ/13/02/05/09

Энэ талаас Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Мал хамгаалах сан цаашид “Зээлдүүлэгч” гэх, Баянхонгор аймаг, Баян-Өндөр сум, Булган, 3-р баг, 0 тоотод үйл ажиллагаа явуулдаг Хоршооны дарга Зэсхүү овогтой Нина (цаашид “Зээлдэгч” гэх), нар харилцан тохиролцож 13 дугаар сарын 17-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

**Нэг. Гэрээний ерөнхий зүйл**

Энэхүү гэрээний зорилго нь Монгол Улсын Иргэний хуулийн 281 дүгээр зүйл, Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны төрийн нарийн бичгийн даргын 2013 оны 08 дугаар сарын 20-ний өдрийн А.299 дугаар тушаалыг үндэслэн иргэн, хуулийн этгээдэд хөнгөлөлттэй нөхцөл бүхий зээлийг олгох, зээлийн зарцуулалтанд зээлдүүлэгч хяналт тавих, зээлийг буцаан төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

**Хоёр. Зээлийн хэлбэр, хэмжээ, хүү, хугацаа, зориулалт**

Зээлдүүлэгч нь “ММУХ” хөтөлбөрийн хүрээнд “Малчдын хоршоодыг чадавхижуулахад” зориулалт болгон Зээлдэгчид 35.000.000 / тоогоор / гучин таван сая/үсгээр/ төгрөгийн зээлийг олгоно.

Зээлийн болон барьцааны гэрээг үндэслэн зээлийн санхүүжилтийг олгоно.

Зээлийн хугацаа: - 60 сар / 5 жил /.

Зээлийн хүү нь жилд 2,4 %, сард 0,2 % байна.

**Гурав. Зээл болон зээлийн хүүг төлөх**

Зээл, зээлийн хүүг энэхүү гэрээний хавсаргалтаар баталсан хуваарийн дагуу “Мал хамгаалах сан”- ийн Төрийн сан дахь 900019044 тоот дансанд шилжүүлнэ.

Зээлдэгч авсан зээл, түүний хүүг зөвхөн төгрөгөөр гүйцэтгэнэ.

Зээлдэгч зээл, зээлийн хүүг хугацаанаас нь өмнө төлж болно.

Зээлдүүлэгч энэ гэрээнд заасны дагуу зээл, түүний хүүг төлөх хугацаа дуусгавар болохоос 30 хоногийн өмнө зээлдэгчид болон батлан даагчид албан ёсоор мэдэгдэнэ.

Гэрээнд хавсаргасан зээл төлөлтийн хуваарь нь зээлийн гэрээний салцгүй хэсэг байна.

**Дөрөв. Зээлдүүлэгчийн эрх, үүрэг**

Мал хамгаалах сан дараах эрх, үүрэгтэй:

Зээлийг зориулалт бусаар зарцуулсан, гэрээний үүргийг зөрчсөн тохиолдолд зөрчил, дутагдлыг арилгахыг шаардах, зээлийн гэрээг нэг талаас цуцлан зээлийн төлбөрийг нэхэмжлэх, шаардлагатай тохиолдолд мэргэжлийн хяналтын байгууллагад хүсэлт гарган



*[Signature]*

*[Signature]*

71  
хяналт тавиулах, гэрээний үүргээ биелүүлээгүйн улмаас зээлдүүлэгчид учирсан хохирлыг хөндмжлэх, хуульд заасны дагуу хохирлыг төлүүлэх арга хэмжээ авна

Зээл олгосны дараа зээлийн зарцуулалт, ашиглалтыг хянаж шалгах үүднээс зээлдэгчээс жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийг авч, зээлийн зарцуулалттай газар дээр нь очиж танилцах;

Зээлдэгчийн санхүүгийн чадвар, бусад банкнаас зээлтэй эсэх талаарх мэдээллийг холбогдох байгууллагаас авах;

Зээлдэгчээс үл хөдлөх эд хөрөнгийн барьцаа гаргуулж авна.

Барьцааны гэрээ хүчин төгөлдөр болсон үеэс барьцаалсан хөрөнгийн ҮХХГэрчилгээг гэрээнд заасан хугацаагаар эзэмшилдээ байлгах.

#### **Мал тамгаалах сан дараах үүрэгтэй:**

Зээлдэгчээс гэрээг байгуулахад шаардлагатай холбогдох материалыг гаргуулан авч шаардлага хангасан тохиолдолд зээлийн гэрээ байгуулах.

Зээлийн зарцуулалтанд хяналт тавьж, эргэн төвлөрүүлэлтийг нь хариуцах.

Зээлийн болон барьцааны гэрээг байгуулсаны дараа, зээлдэгчид зээлийг олгох;

#### **Тав. Зээлдэгчийн эрх, үүрэг**

##### **Зээлдэгч дараах үүрэгтэй.**

Зээлийн гэрээ байгуулахтай холбоотой гарах бүх зардлыг зээлдэгч бүрэн хариуцана.

Гэрээгээр хүлээх эрх, үүргийг өөр этгээдэд шилжүүлэхгүй бөгөөд зээлдэгч дампуурсан, татан буугдсан, нас барсан тохиолдолд түүний үүргийг хууль ёсны залгамжлагч, өвлөгч Монгол Улсын "Иргэний хууль"-ийн 535-д заасны дагуу хариуцна.

Зээлийн ашиглалтад зээлдүүлэгчээс хяналт тавих бололцоогоор хангана.

Гэрээний хавсралтад заасан хуваарийн дагуу зээл, зээлийн хүүг Зээлдүүлэгчийн Төрийн сангийн 900019044 тоот дансанд төлөх;

Зээл, зээлийн хүүг хуваарийн дагуу 2019 оны 04 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд бүрэн төлж дууссан байх

Зээлийг зориулалтын дагуу ашиглах

Зээлийн ашиглалтын талаарх мэдээлэл, тухайлбал төслийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн тухай мэдээ танилцуулга, сар, улирлын тайлан тэнцэл зэргийг жил бүрийн 10 дугаар сард гаргаж Зээлдүүлэгчид ирүүлж байх.

Зээлдэгч нь зээлийн гэрээг нотариатаар батлуулж, үл хөдлөх эд хөрөнгийн газарт бүртгүүлснээр зээл авах эрх нь нээгдэнэ.

#### **Зургаа. Барьцаа**

Хоёр тал Монгол улсын "Иргэний хууль"-ийн 153-181 дугаар зүйлийг болон ҮХЭХ-ийн Барьцааны тухай хуулийг дагаж мөрдөнө.

Зээлдүүлэгч зээлийн гэрээний үүргийн биелэлтийг хангуулахаар үл хөдлөх эд хөрөнгө барьцаалах ба барьцааны гэрээ нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.

#### **Долоо.Хариуцлага**

Гэрээний үүргийг биелүүлэхтэй холбогдсон аливаа маргааныг харилцан тохиролцож шийдвэрлэх ба харилцан тохиролцож чадахгүйд хүрвэл шүүхээр шийдвэрлүүлнэ.



Эзэл, зээлийн хүүг хуваарийн дагуу төлөөгүй тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээс хугацаа хэтэрсэн хоног тутамд 0.5 хувийн алданги зээлдэгч тал зээлдүүлэгч талд төлнө.

Зээлдэгч зээлийн төлбөрийг зээл төлөлтийн хуваарийн дагуу хугацаандаа төлөөгүй тохиолдолд зээлдүүлэгч гэрээг хугацаанаас нь өмнө дангаараа цуцалж шүүхийн байгууллагад шилжүүлнэ.

Зээлдэгч тал гэрээний үүргээ биелээгүй нь тухайн аж ахуйн нэгж, түүний захирал, төлөөлөх эрхтэй этгээд, иргэнд Үйлдвэр, хөдөө аж ахуйн салбарт хэрэгжүүлж байгаа хөнгөлөлттэй зээл, тасал, хөтөлбөр, хөрөнгө оруулалт зэрэг арга хэмжээнд оролцуулахаас татгалзах үндэслэл болно.


Зээлийг хугацаандаа төлөөгүйн улмаас гарах зардлыг зээлдэгч тал хариуцана.

Гэрээг хуулийн хүчин төгөлдөр бөгөөд 5 хувь үйлдэж, нотариатаар гэрчлүүлнэ. Зээлдүүлэгч тал 2 хувь, зээлдэгч тал 1 хувь хадгална.

### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

ХАМГААЛАХ САНГИЙН

ЗАХИРАЛ:




П.МӨНХБАЯР

МЭРГЭЖИЛТЭН



Я.ОТГОНБААТАР




“БНЭ” ХОРШООНЫ ДАРГА

ХОРШОО

З.НИНА


### ГЭРЭЭ ХЯНАСАН:

ХАМГААЛАХ САНГИЙН ДЭД ЗАХИРАЛ:



Ц.БОЛОРЧУЛУУН

МЭРГЭЖИЛТЭН:



Б.МӨНХ-ЭРДЭНЭ

Зээлдэгч талын хаяг

БЗД


Газрын 9-р байр

Увсаны өргөн чөлөө 16А

Утас: 453233

Харуулах банк: Төрийн сан

Дугаар: 900019044



“БНЭ” Хоршоо

Үйл ажиллагаа явуулдаг

газрын хаяг: Баянхонгор аймаг,  
Баян-Өндөр сум, Булган 3-р баг,  
0 тоотод

Регистр: 2396971

Бүртгэлийн дугаар: 330001046

Банк: ХААН банк

Дансны дугаар: 5231001017

Утас: 88606630, 86897970,


88179327, 88902136

Захирлын овог нэр: Зэсхүү

Нина

Хаяг: Баянхонгор, Баян-Өндөр,  
Булган, 3-баг

Регистр: ВД56041902



ММҮХ/ТШ/13/02/05/09 ТООТ ГЭРЭЭНИЙ ХАВСРАЛТ

Зээлийн хүүг хуваарийн дагуу төлж барагдуулна

	Зээлийн үлдэгдэл	Зээлийн үндсэн төлбөр	Зээлийн хүү	Нийт төлбөр
	35,000,000.00	7,000,000.00	840,000.00	7,840,000.00
	28,000,000.00	7,000,000.00	672,000.00	7,672,000.00
	21,000,000.00	7,000,000.00	504,000.00	7,504,000.00
	14,000,000.00	7,000,000.00	336,000.00	7,336,000.00
	7,000,000.00	7,000,000.00	168,000.00	7,168,000.00
<b>НИЙТ</b>		<b>35,000,000.00</b>	<b>2,520,000.00</b>	<b>37,520,000.00</b>


хүүг "Төрийн сан"-дахь Мал хамгаалах сангийн 900019044 тоот дансанд төлөх.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Төлөөлж

Зээлдэгч

МАЛ ХАМГААЛАХ САНГИЙН



П.МӨНХБАЯР

З.НИНА

МЭРГЭЖИЛТЭН:

Я.ОТГОНБААТАР

ГЭРЭЭ ХЯНАСАН:

МАЛ ХАМГААЛАХ САНГИЙН ДЭД ЗАХИРАЛ:

*Б.Мөнх-Эрдэнэ* Ц.БОЛОРЧУЛУУН

МЭРГЭЖИЛТЭН:

*Б.Мөнх-Эрдэнэ*

Б.МӨНХ-ЭРДЭНЭ

